



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ “МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД
ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ НИЙЦҮҮЛЭХ, ТҮҮНТЭЙ
ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” 02 ДУГААР ТОГТООЛЫН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

Хуудасны дугаар

УДИРТГАЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3

НЭГ.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ 02 ДУГААР ТОГТООЛЫН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

4-5

ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТӨД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ НИЙЦҮҮЛСЭН
ТАЛААР

5-16

2.1. Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангах агуулгын хүрээнд:

2.2. Гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд:

2.3. Шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд:

2.4. Нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд:

ГУРАВ.МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙГ УЛС ОРОН ДАЯАР СУРТАЛЧЛАХ АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛСАН ТАЛААР

16-18

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

18-19

Хавсралт 1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн баталсан хууль тогтоомжийн талаарх товч мэдээлэл

Хавсралт 2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хүрээнд гүйцэтгэсэн судалгааны ажлын жагсаалт

УДИРТГАЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл баримтлалд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлж эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх, мөн нэмэлт, өөрчлөлтийн ач холбогдлыг ард түмэнд сурталчлан таниулах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолыг баталсан.

Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгээс тус тогтоолын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийлгэх санал ирүүлсний дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 110 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын цаглавар”-т тусгасан.

Улсын Их Хурлын Тамгын газраас уг тогтоолын хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу бүхэлд нь хяналт шинжилгээ хийсэн болно.

Хяналт шинжилгээ хийхдээ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн баталсан хууль тогтоомж нь уг тогтоолд заасан үзэл баримтлалыг тусгасан эсэх, мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн ач холбогдлыг ард түмэнд сурталчлан таниулах ажлыг үр дүнтэй зохион байгуулсан эсэхийг тогтооход чиглэгдлээ.

Хяналт шинжилгээг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн баталсан болон өргөн мэдүүлсэн хууль тогтоомж, түүний хувийн хэрэг, мөн Засгийн газрын газрын Хэрэг эрхлэх газар, Улсын Их Хурлын Тамгын газрын бүтцийн нэгжүүдээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн гүйцэтгэсэн болно.

НЭГ.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ 02 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ТАЛААР

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг баталсан.

Тус хуваарьт заасны дагуу анхдагч хууль 3, хуулийн шинэчилсэн найруулга 12, хуулийн нэмэлт, өөрчлөлт 16 буюу нийт 31 хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн батлахаар тусгасан.

Үүнээс 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар анхдагч хууль 1, хуулийн шинэчилсэн найруулга 12, хуулийн нэмэлт өөрчлөлт 6 буюу нийт 19 хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн баталсан байна. Мөн тогтоолын хавсралтад заасан хуваарьт тусгагдаагүй ч 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд боловсруулан баталсан тул тогтоолын хэрэгжилтэд оруулж тооцсон болно.

Нийт 32 хуулиас 19 хууль буюу 59.4 хувийг баталж, 13 хууль буюу 40.6 хувийг батлаагүй байна. */Хавсралт 1-ээс Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн баталсан хууль тогтоомжийн товч мэдээллийг үзнэ үү! /*

Хүснэгт 1.Нийцүүлэн баталсан хууль тогтоомжийн талаарх статистик мэдээлэл

Хэрэгжилт	Хуулийн тоо	Хувь
Тогтоолын хавсралтад заасан хууль Үүнээс батлагдсан:	32 ¹	100.0%
- Анхдагч хууль	1	3.1%
- Шинэчилсэн найруулга	12	37.5%
- Нэмэлт, өөрчлөлт	6	18.8%
Хэрэгжилтийн дундаж		59.4%

Монгол Улсын Их Хурлаас уг тогтоолын дагуу баталсан нийт 19 хууль тогтоомжийг батлагдсан хугацаагаар нь авч үзвэл, 2020 онд 10 хууль, 2021 онд 8 хууль, 2022 онд 1 хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн тус тус баталсан байна.

Хүснэгт 2.Тогтоолын хавсралтад заасан хуваарийн дагуу батлагдсан хууль тогтоомжийн огнооны талаарх статистик мэдээлэл

Батлагдсан огноо	Хуулийн тоо	Хувь
Тогтоолын хавсралтад заасан хуваарийн дагуу батлагдсан хууль Үүнээс:	19	100.0%
- 2020 онд батлагдсан	10	52.6%
- 2021 онд батлагдсан	8	42.1%
- 2022 онд батлагдсан	1	5.3%

Монгол Улсын Их Хурлаас баталсан 19 хуулиас Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийг шинэчлэн найруулахаар тогтоолд заасан боловч нэмэлт, өөрчлөлт, Мэдээллийн ил

¹ Тогтоолын хавсралтад заасан хуваарьт тусгагдаагүй ч 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд боловсруулан баталсан тул тогтоолын хэрэгжилтэд оруулж тооцсон болно.

тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тогтоолд заасан боловч шинэчилсэн найруулгаар тус тус баталсан байна.

Мөн Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн сахилгын хорооны тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тогтоолд тусгасан боловч эдгээр 4 хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг агуулгын хувьд нэгтгэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулж баталсан байна.

Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн батлаагүй нийт 13 хуулиас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлгийн шатанд байгаа дараах 4 хуулийн төсөл байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн төсөл;
- Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн “Улс төрийн намын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг болно.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын даргын 2021 оны 03 дугаар захирамжаар байгуулагдсан “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байгаа бөгөөд тогтоолын хавсралтад заасан хуваарийн дагуу нийт 9 хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байна.

Хүснэгт 3. Тогтоолын хавсралтад заасан хуваарийн дагуу батлагдах хууль тогтоомжийн талаарх статистик мэдээлэл

Хэрэгжилт	Хуулийн тоо	Хувь
Тогтоолын хавсралтад заасан хуваарийн дагуу батлах хууль	32	100.0%
Үүнээс:		
- Батлагдсан	19	59.4%
- Өргөн мэдүүлсэн буюу хэлэлцүүлгийн шатанд	4	12.5%
- Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан /өргөн мэдүүлээгүй/	1	3.1%
- Өргөн мэдүүлээгүй	8	25.0%

ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ НИЙЦҮҮЛСЭН ТАЛААР

Тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан бөгөөд хуваарьт заасны дагуу дараах 4 агуулгын хүрээнд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэхээр заасан. Үүнд:

1. Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангах;
2. Гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт;
3. Шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт;
4. Нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлт.

2.1.ПАРЛАМЕНТЫН АРДЧИЛЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЖ, АРД ТҮМНИЙ ЗАСАГЛАХ ЭРХИЙГ ХАНГАХ АГУУЛГЫН ХҮРЭЭНД:

Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангах хүрээнд нийт **18** хууль тогтоомжийг нийцүүлэхээр заасан. Үүнээс батлагдсан 8 хууль, өргөн мэдүүлж, хэлэлцүүлгийн шатанд байгаа 4 хуулийн төсөл, өргөн мэдүүлээгүй 6 хууль байна.

Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангах хүрээнд нийт 4 чиглэлийн үзэл баримтлалыг тусгасан бөгөөд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлсэн байдлыг авч үзвэл:

2.1.1.Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд тогтоолд заасан үзэл баримтлалыг тусгасан эсэх талаар:

Энэ хүрээнд нийт 9 хуулийн төслийг боловсруулан 2020 онд батлахаар тогтоолд заасан. Үүнээс Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн **баталсан** дараах **2 хууль** байна. Үүнд:

1. 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийг шинэчлэн найруулж “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийг баталсан;
2. 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлгийн шатанд байгаа дараах **3 хуулийн төсөл** байна. Үүнд:

1. 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
2. 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
3. 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг болно.

Монгол Улсын Их Хурлаас баталсан 2 хууль, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлгийн шатанд байгаа дээрх 3 хуулийн төсөлд тогтоолд заасан үзэл баримтлалыг тусгасан эсэхийг хянан үзвэл:

1. “**Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль**”-ийн шинэчилсэн найруулгыг 8 бүлэг, 38 зүйлтэйгээр баталсан. Тус хуульд тогтоолын хавсралтад заасан “*Газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг баталгаажуулах, Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхийг зөрчиж байгаа эсэхэд иргэд хөндлөнгийн хяналт тавих эрх зүйн үндсийг тогтоох*” гэсэн агуулгыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.9-д “хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл”-ийг ил тод, нээлттэй байлгана гэж, 8.6.10-д “мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн,

мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл"-ийг ил тод, нээлттэй байлгана гэж;

- хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ” гэж тус тус тусгасан байна.

Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхийг зөрчиж байгаа эсэхэд иргэд хөндлөнгийн хяналт тавих эрх зүйн үндсийг тогтоох харилцааг тус хуульд тухайлан заагаагүй ч иргэд цахим хуудсанд байршуулсан нээлттэй мэдээлэлтэй танилцах, эсхүл мэдээлэл хариуцагчид хандан амаар болон бичгээр хүсэлт гарган нээлттэй болон хязгаарлалттай мэдээлэлтэй танилцах нөхцөл бүрдсэн нь нэг талаар иргэн хяналтаа тавих нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна.

2. **“Төрийн хяналт шалгалтын тухай хууль”**-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус нэмэлт, өөрчлөлтөөр нийт 22 зүйл, 44 хэсэг, заалтад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулж, 3 зүйлийн 3 хэсгийг хасаж, 4 хэсгийг хүчингүй болсонд тооцсон байна. Тус хуульд тогтоолын хавсралтад заасан *“Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох”* гэсэн агуулгыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар ноцтой аюул болон их хэмжээний хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналт шалгалтыг хяналт шалгалтын байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр энэ хуулийн 5.2-т заасан удирдамжгүйгээр хийж болно.” гэж, мөн 5³.1-д “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хийнэ.” гэж;
- хуулийн 5⁵ дугаар зүйлийн 5⁵.1-д “Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болох хор хохирол, үр дагаврыг харгалзан хяналт шалгалтын объектын эрсдэлийг бага, дунд, их хэмжээний гэж ангилна” гэж, 5⁵.2-т “Энэ хуулийн 5⁵.1-д заасан шалгуур, үзүүлэлтийг тогтоох эрхийг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газарт олгосон бол 5⁵.3-д 5⁵.2-т заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалт, шалгалтад хамруулах давтамжийн хугацааг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.” гэж;
- мөн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд хуулийн 9 дүгээр зүйлд хяналт шалгалтын байгууллагын бүрэн эрхийг, 10 дугаар зүйлд улсын байцаагчийн бүрэн эрхийг тус тус тусгасан байна.

3. **“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”**-ийн шинэчилсэн найруулгын төслийг хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хамт Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлгийн шатанд байна. Тус хуулийн төсөлд тогтоолын хавсралтад заасан *“Төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгох”* гэсэн агуулгыг хуулийн төслийн 7 дугаар зүйлд төрийн өмчийн ангиллын талаар, 8 дугаар зүйлийн 8.1-д төрийн нийтийн өмчид хамаарах Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар ард түмний мэдэлд байх байгалийн баялаг, хөрөнгийн талаар, 8.2-т Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар төрийн хамгаалалтад байхаар заасан болон үр өгөөжийг нь нийт ард түмэнд хүртээхээр заасан баялаг, хөрөнгө, нийтийн өмчийн

талаар, 8.3-т мөн хуульд заасан төрийн нийтийн өмчийг хуульд заасны дагуу ашиглах, үр шимийг нь хүртэх эрхийн талаар, 11 дүгээр зүйлд төрийн өмчийн өмчлөл, төрийн болон орон нутгийн өмчийн талаарх Улсын Их Хурлын бүрэн эрх, 12 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрх, 26 дугаар зүйлд төрийн өмчийн бүртгэлийн талаар, 31 дүгээр зүйлд төрийн болон төрийн нийтийн өмчийн тооллоготой холбоотой зохицуулалтын талаар тус тус тусгажээ.

4. **“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”**-д 3 зүйлийн 3 хэсэг, заалт бүхий нэмэлт оруулах хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлгийн шатанд байна. Тус хуулийн төсөлд тогтоолын хавсралтад заасан *“Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхтэй холбогдсон зохицуулалтыг нэмэх”* гэсэн агуулгыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдэх.” гэж;
- хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.2.11-т “харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, байгаль орчны төлөв байдлын мэдээлэлд тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.” гэж тус тус тусгасан байна.

5. **“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”** болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлгийн шатанд байна. Тогтоолын хавсралтад заасан *“Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхтэй холбогдсон зохицуулалтыг нэмэх”* гэсэн агуулгыг тус хуулийн төсөлд дараах байдлаар нэмэлтээр тусгажээ. Үүнд:

- хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.4-т “иргэний хүсэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах үүрэгтэй.” гэж;
- хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Иргэн тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргана.” гэж, 18.6-д “Засаг дарга иргэний энэ хуулийн 18.5-д заасан хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.8-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй” гэж, 18.7-д “Иргэн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах боломж олгох хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.” гэж тус тус тусгасан байна.

Харин тогтоолд заасан хуваарийн дагуу Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд **өргөн мэдүүлээгүй** дараах **4 хуулийн төсөл** байна. Үүнд:

1. “Ашигт малтмалын тухай хууль” болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
2. “Цөмийн энергийн тухай хууль” болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
3. “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн анхдагч хуулийн төсөл;
4. “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль” болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг болно.

2.1.2.Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, төсөв, санхүүтэй холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд тогтоолд заасан үзэл баримтлалыг тусгасан эсэх талаар:

Энэ хүрээнд нийт 4 хуулийн төслийг боловсруулан 2020 онд батлахаар тогтоолд заасан. Үүнээс Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан дараах 3 хууль байна. Үүнд:

1. 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталсан;
2. 2022 оны 12 дугаар сарын 24-ний өдөр “Төсвийн тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан;
3. 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр “Төрийн аудитын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, төсөв, санхүүтэй холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан баталсан дээрх 3 хуульд тогтоолд заасан үзэл баримтлалыг тусгасан эсэхийг хянан үзвэл:

1. **“Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”**-ийг 7 бүлэг, 25 зүйлтэйгээр хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн хамт баталсан байна. Тус хуульд тогтоолын хавсралтад заасан *“Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан Засгийн газрын үндсэн бүтцийн нэгж, байгуулах бөгөөд улс төрийн сонгуулийн мөчлөгөөс үл хамааран тогтвортой ажиллах зохицуулалтыг бий болгох”* гэсэн агуулгыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо нь улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгжтэй байх, мөн суманд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан ажилтнаас бүрдэнэ” гэж, 7.2-т “...салбарын түвшинд тухайн салбарын сайд, тухайн салбарын төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн түвшинд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нар удирдана” гэж тусгасан байна.

- хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “30 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэх Алсын хараа нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байна” гэж зааж өгснөөр улс төрийн сонгуулийн мөчлөгөөс үл хамааран тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хүрээнд баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,

түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нийцүүлэн **“Төсвийн тухай хууль”**-д 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд нэмэлт, өөрчлөлтөөр тогтоолын хавсралтад заасан *“Жил бүрийн улсын төсөв нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд суурилсан байх шаардлагыг хуульчлах”* гэсэн агуулгыг тусгасан.

Харин тогтоолын хавсралтад заасан *“Улсын Их Хурал Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн улсын төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болох зохицуулалтыг тусгах”* гэсэн агуулгыг 2017 онд Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр буюу тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт тусгасан байна. Өөрөөр хэлбэл, тогтоол батлагдахаас өмнө тус агуулгыг Төсвийн тухай хуульд тусгажээ.

Мөн тогтоолын хавсралтад заасан *“Улсын Их Хурлаас төсвийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгох”* гэсэн агуулгыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хүрээнд баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт тусгасан.

3. **“Төрийн аудитын тухай хууль”**-ийн шинэчилсэн найруулгыг 6 бүлэг, 42 зүйлтэйгээр баталсан. Тогтоолын хавсралтад заасан *“Төрийн аудитын байгууллагын бие даасан, үйл ажиллагааны хараат бус байдлыг сайжруулах, эрх хэмжээг нэмэгдүүлэх”, мөн “зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх”* гэсэн агуулгыг тус хуульд дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д хуулийн зорилгыг *“... төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино.”* гэж;
- хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д *“Төрийн аудитад хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод, бодитой байх, төрийн аудитын олон улсын нийтлэг стандартад нийцсэн байх зарчмыг баримтална.”* гэж;
- хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д *“Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага байна.”* гэж;
- хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т *“Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг зөвхөн энэ хуулиар тогтоох бөгөөд бусад хуулиар төрийн аудитын байгууллагад Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиар тодорхойлсон төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд хамаарахгүй чиг үүрэг нэмэгдүүлэхийг хориглоно.”* гэж;
- хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д *“Төрийн аудитын байгууллага Засгийн газраас хараат бус байх бөгөөд Засгийн газраас төрийн аудитын байгууллагад аливаа хэлбэрээр чиглэл, үүрэг, даалгавар өгөхийг хориглоно.”* гэж;

- хуулийн 40 дүгээр зүйлийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “Төрийн аудитын байгууллага улсын төсвөөс санхүүжнэ. Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг төр хангана.” гэж тус тус тусгасан байна.

Харин Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр “Улс төрийн намын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тус хуулийн төсөлд тогтоолын хавсралтад заасан “Сонгуульд өрсөлдөх улс төрийн намын мөрийн хөтөлбөрийн зорилт нь хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөлтөд нийцсэн байх шаардлагыг тусгах, шаардлага хангагдаагүйгээс үүсэх хууль зүйн үр дагаврыг хуульчлах” гэсэн агуулгыг тодорхой тусгаагүй байна.

2.1.3. Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгож, хариуцлагыг сайжруулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд тогтоолд заасан үзэл баримтлалыг тусгасан эсэх талаар:

Энэ хүрээнд нийт 4 хуулийн төслийг боловсруулан 2020 онд батлахаар тогтоолд заасан. Үүнээс Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан дараах 3 хууль байна. Үүнд:

1. 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталсан;
2. 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Хууль тогтоомжийн тухай хууль”-д өөрчлөлт оруулсан;
3. 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог сайжруулах хүрээнд баталсан дээрх 3 хуульд тогтоолд заасан үзэл баримтлалын агуулгыг тусгасан эсэхийг хянан үзвэл:

1. “Монгол Улсын Их Хурлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг 7 бүлэг 51 зүйлтэйгээр баталсан. Тус хуульд тогтоолын хавсралтад заасан “Ээлжит чуулганы үргэлжлэх хугацааг 75-аас доошгүй ажлын өдөр болгон нэмэгдүүлсэнтэй холбогдуулан ээлжит чуулганы нээх, хаах хугацааг зохицуулах”, “Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо байгуулахтай холбогдсон зохицуулалтыг хуульчлах” гэсэн агуулгыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган 10 дугаар сарын 01-ний өдрөөс, хаврын ээлжит чуулган 3 дугаар сарын 15-ны өдрөөс тус тус эхлэн 75-аас доошгүй ажлын өдөр чуулна.” гэж;

- хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д Хянан шалгах түр хороог байгуулахтай холбоотой заалтыг тус тус тусгасан байна.

2. “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 2 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан. Тус өөрчлөлтөд тогтоолын хавсралтад заасан “Хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаартай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах” гэсэн агуулгыг хуулийн 2.1.1-д “хууль санаачлагч гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийг”, 2.1.2-т “хууль санаачлах эрх гэж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хүрээ, хязгаарт нийцүүлэн энэ хуулийн 2.1.1-д заасан этгээдээс мэргэжлийн түвшинд боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг” ойлгоно гэж тус тус тусгажээ.

3. **“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль”**-ийн шинэчилсэн найруулгыг 14 бүлэг 131 зүйлтэйгээр баталсан байна. Тус хуульд тогтоолын хавсралтад заасан *“Улсын Их Хурлаар улсын төсвийг хэлэлцэн батлах дэгийг боловсронгуй болгох”* гэсэн агуулгыг хуулийн 8 дугаар бүлэгт, *“Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хуралд танилцуулах журмыг тогтоох”* гэсэн агуулгыг хуулийн 30 дугаар зүйлд тус тус тусгажээ.

Тогтоолын хавсралтад заасан хуваарьт тусгагдаагүй хэдий ч Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр **“Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль”**-ийг баталсан. Тус хууль батлагдсанаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлаас хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх арга хэрэгсэл, үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан байна. Тухайлбал, хуулийн Зургадугаар бүлэгт Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо байгуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тусгасан.

Харин “Ард нийтийн санал асуулгын тухай хууль”-д тогтоолын хавсралтад заасан агуулгын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байна.

2.1.4. Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд баримтлах чиглэлийн хүрээнд:

Энэ хүрээнд нийт 2 хуулийн төслийг боловсруулан 2020 онд батлахаар тогтоолд заасан. Үүнээс Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн “Улс төрийн намын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Харин “Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль”-ийн төслийг өргөн мэдүүлээгүй байна.

“Улс төрийн намын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг 46 зүйлтэйгээр өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төсөлд тогтоолын хавсралтад заасан агуулгыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- *“Намын чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаа хууль дээдлэх зарчимд суурилсан байх”* гэсэн агуулгыг хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.” гэж, 5 дугаар зүйлийн 5.2-т “Аль нэг намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд иргэнийг болон тухайн намыг аливаа хэлбэрээр мөшгөн хавчих, заналхийлэх, дарамтлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно.” гэж, 7 дугаар зүйлийн 7.2-т “Нам нь Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх үүрэгтэй.” гэж, 9 дүгээр зүйлд “Намын үйл ажиллагааг цахимаар явуулах, ил тод байдлыг хангах” гэж тусгасан байна;
- *“Улс төрийн намын хариуцлагын тогтолцоог тодорхой болгох”* гэсэн агуулгыг хуулийн төсөлд дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал, хуулийн төслийн 10 дугаар зүйлд намын үйл ажиллагаанд хориглох үйл ажиллагааны талаар, Дөрөвдүгээр бүлэгт намыг идэвхгүйд тооцох, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой зохицуулалтын талаар, 31 дүгээр зүйлд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналтын талаар, 37 дугаар зүйлд нам нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн анхан шатны баримт хөтлөөгүй, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн баримтыг Архивын тухай хуулийн дагуу хадгалаагүй тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх талаар, 39 дүгээр зүйлд намын санхүүгийн тайланг нягтлан шалгахтай

холбоотой зохицуулалтын талаар, 45 дугаар зүйлд хууль зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан байна.

- *“Улс төрийн намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нийтэд ил тод байх”* гэсэн агуулгыг хуулийн төсөлд дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал, хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т нам нь өөрийн санхүүгийн тайланг ил тод, нээлттэй байлгаж, нийтэд тогтмол мэдээлэх, мэдээлэл авах боломжоор хангах талаар, 9.6.9-д нам санхүүгийн тайлангаа цахим хуудастаа ил тод байршуулж, тухай бүр шинэчлэх талаар, 9.7-д намын дансанд хүлээж авсан хандивын болон бусад мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу тайлагнах, 9.8-д жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан цахим хуудастаа байршуулж олон нийт, гишүүд, дэмжигчдэдээ ил тод мэдээлж, нээлттэй танилцуулдаг байх зохицуулалтыг тусгасан байна.
- *“Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох”* гэсэн агуулгыг хуулийн төслийн Тавдугаар бүлэгт тусгасан бөгөөд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь намын орлогын эх үүсвэрийн нэг байхаар, мөн төрөөс олгох санхүүжилт, түүний хэмжээ болон төрийн санхүүжилт авах хүсэлт гаргахтай холбоотой зохицуулалтыг тусгасан байна.
- *“Сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэний дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах журмыг тогтоох”* гэсэн агуулгыг хуулийн төсөлд бүрэн тусгаагүй бөгөөд харин хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.7-д заасан агуулгыг тус хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.3.6-д дахин тусгасан буюу намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэлийг нам бүртгүүлэх өргөдөлд хавсаргахаар тусгажээ.

2.2.ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДЭЛТЭЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

Гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд нийт **3** хууль тогтоомжийг нийцүүлэхээр тогтоолд заасан. Үүнээс батлагдсан 2 хууль, өргөн мэдүүлээгүй 1 хуулийн төсөл байна.

2.2.1.Засгийн газрыг эмхлэн байгуулах болон Ерөнхий сайдад илтгэл үзүүлэх тухай нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хуулийн төсөлд тогтоолд заасан үзэл баримтлалыг тусгасан эсэх талаар:

Энэ хүрээнд **“Монгол Улсын Засгийн газрын тухай”** хуулийн шинэчилсэн найруулгыг батлахаар тогтоолд заасан боловч 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “Монгол Улсын Засгийн газрын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус нэмэлт, өөрчлөлтөд тогтоолын хавсралтад заасан агуулгыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- *“Ерөнхий сайд өөрт нь итгэл үзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хуралд оруулах зохицуулалтыг хуульчлах”* гэсэн агуулгыг хуулийн 4 дүгээр зүйлд “Ерөнхий сайдыг огцруулах, шинээр томилох, чөлөөлөх болон Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай асуудлыг Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Дөчин гуравдугаар зүйл, Дөчин дөрөвдүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн Аравдугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу Улсын Их Хурал шийдвэрлэнэ.” гэж;
- *“Засгийн газар танхимаар ажиллах зарчимд нийцүүлэн Ерөнхий сайд бие*

даан танхимаа бүрдүүлэх зохицуулалтыг хуульчлах” гэсэн агуулгыг хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын гишүүнийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тус тус заасны дагуу Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулахдаа захирамж гаргана.” гэж тус тус тусгасан байна.

2.2.2.Ерөнхийлөгчид нэр дэвших насны босго, бүрэн эрхийн хугацааг нэмэх талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд тогтоолд заасан үзэл баримтлалыг тусгасан эсэх талаар:

Энэ хүрээнд 2 хуулийн төслийг боловсруулан 2020 онд батлахаар тогтоолд заасан бөгөөд үүнээс 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр “**Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль**”-ийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн хуулийг баталсан байна.

Тус хуульд тогтоолын хавсралтад заасан “*Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх*” гэсэн агуулгыг хуулийн 3.1.2-т “нэр дэвшигч гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэг, энэ хуульд заасан шаардлагыг хангаж Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшин бүртгүүлж, нэр дэвшигчийн үнэмлэх авсан Монгол Улсын иргэнийг” гэж заасан. Тус заалтын “...50 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан,...уугуул” гэж заасныг Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 2 дугаар дүгнэлтээр “Үндсэн хууль зөрчсөн байна” гэж үзэн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн байх бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 38 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн байна.

Харин “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байна.

2.3.ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАЖ, ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

Шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд нийт 6 хууль тогтоомжийг нийцүүлэхээр тусгасан. Үүнээс 4 хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг нэгтгэн баталсан 1 хууль, нэмэлт, өөрчлөлт оруулсан 1 хууль, өргөн мэдүүлээгүй 1 хуулийн төсөл байна.

Тодруулбал, Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн сахилгын хорооны тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг нэгтгэн 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр “**Монгол Улсын шүүхийн тухай хууль**”-ийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Тус хуульд тогтоолын хавсралтад заасан “*Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүнд тавих болзол, шалгуур, тэдгээрийг сонгох, томилох, Зөвлөлийн даргыг сонгох журам*”-ын хүрээнд хуулийн 76 дугаар зүйлд “Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүнд тавих болзол, шалгуур, тэдгээрийг сонгох, томилох болон бүрэн эрхийн хугацааны талаар”, 77 дугаар зүйлд “Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилох, сонгох журмын талаар” тус тус тусгажээ.

Мөн тогтоолын хавсралтад заасан “*Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн, гишүүнд тавих болзол, шалгуур, бүрдүүлж байгуулах журмыг тогтоох*” гэсэн агуулгыг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.4-т “...Сахилгын хорооны

бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно...” гэж тусгасан байна. Тус заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 3 дугаар дүгнэлтээр түдгэлзүүлсэн боловч Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 2 дугаар тогтоолоор тус дүгнэлтийг хүчингүй болсонд тооцсон.

Харин “Шүүх байгуулах тухай хууль”-ийн төслийг 2021 онд хэлэлцэн батлахаар тогтоолд заасан боловч тус хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байна.

2.4.НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

Энэ хүрээнд нийт 4² хуулийн төслийг боловсруулан 2020 онд батлахаар тогтоолд заасан. Үүнээс Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан дараах 3 хууль байна. Үүнд:

1. 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталсан байна;
2. 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталсан байна;
3. 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр “Татварын ерөнхий хууль” болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд баталсан дээрх 3 хуульд тогтоолд заасан үзэл баримтлалын агуулгыг тусгасан эсэхийг хянан үзвэл:

1. **“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”**-ийн шинэчилсэн найруулгыг 6 бүлэг 81 зүйлтэйгээр баталсан. Тус хуульд тогтоолын хавсралтад заасан агуулгыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:
 - *“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг хуульчлах”, мөн “Татварын хувь хэмжээг тогтоохтой холбогдсон зохицуулалтыг хуульчлах”* гэсэн агуулгыг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т заасан бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох тухай зохицуулалтыг;
 - *“Төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн тогтоохтой холбогдсон зохицуулалтыг хуульчлах”* гэсэн агуулгыг хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д *“...төсвийн харилцааны үндсийг тухайн нэгжийн газар зүйн байршил, хүн амын тоо, суурьшил, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, ... улсын эдийн засагт үзүүлэх нөлөө зэрэг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тусгайлан зохицуулж болно.”* гэж, мөн 76.3-т *“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн зохицуулах хуулийг зөвхөн Засгийн газар санаачилна.”* гэж;

² Тогтоолын хавсралтад заасны дагуу “Нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлт”-ийн хүрээнд нийт 6 хуулийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэхээр тусгасан бөгөөд үүнээс Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар бусад бүлэгт тусгасан тул хасаж тооцсон болно.

- “Хот, тосгоны эрх зүйн үндсийг тодорхой болгож, тэдгээрийн өөрийн удирдлага, өмчийн болон төсвийн зохицуулалтыг нарийвчлан тусгах” гэсэн агуулгыг хуулийн Дөрөвдүгээр бүлэгт тусгасан бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг хот, тосгонд шилжүүлэх зохицуулалтыг тус тус тусгажээ.

2. **“Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг 7 бүлэг 51 зүйлтэйгээр баталсан.**

Тус хуульд тогтоолын хавсралтад заасан *“Татварын хувь хэмжээг тогтоохтой холбогдсон зохицуулалтыг хуульчлах”* гэсэн агуулгын хүрээнд хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь татварын хууль тогтоомжоор эрх олгож, тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтооно” гэж, мөн 21 дүгээр зүйлийн 21.1.5.-д Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхэд “хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл, үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах зардал зэргийг харгалзан албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох.” гэж заасан байна.

3. **“Татварын ерөнхий хууль”-ийн 3 зүйл, 8 хэсэг, заалтад нэмэлт, 5 зүйл, 9 хэсэг, заалтад өөрчлөлт оруулсан.** Тус нэмэлт, өөрчлөлтөөр тогтоолын хавсралтад заасан *“Татварын хувь хэмжээг тогтоохтой холбогдсон зохицуулалтыг хуульчлах”* гэсэн агуулгыг хуулийн 8 дугаар зүйлд татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл хууль тогтоомжийн дагуу тус тус тогтоохоор, түүнчлэн Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосон тохиолдолд зарим татварын хувь, хэмжээг тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл тогтоож болохоор хуульчилсан байна.

Харин “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулалтын шатанд байна.

ГУРАВ.МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ,ӨӨРЧЛӨЛТИЙГ УЛС ОРОН ДАЯАР СУРТАЛЧЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР

Тогтоолын 5-д “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг улс орон даяар сурталчлах ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт даалгасгай” гэж заасан.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас дараах хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг улс орон даяар сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- хурал, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- судалгаа, ном, хэвлэл бэлтгэн түгээх;
- телевизийн мэдээ, нэвтрүүлэг бэлтгэн түгээх;
- мобайл аппликейшн, олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан мэдээ, мэдээлэл түгээх.

Хурал, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах хүрээнд: Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт тусгагдсан хуулиудын хүрээнд дараах 2 удаагийн эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулжээ. Үүнд:

1. 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр НҮБХХ, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Чимид сантай хамтран “Монгол Улсын Үндсэн хууль ба эрх зүйн шинэтгэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг Төрийн ордонд;
2. 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яам, Ханнс-Зайделын сантай хамтран Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг олон нийтэд сурталчлан танилцуулах хурлыг цахим хэлбэрээр.

Мөн тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс дараах 9 сургалт, хэлэлцүүлэг цахим болон танхимаар зохион байгуулжээ. Үүнд:

Хүснэгт 4. Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг

Д/д	Сургалт, хэлэлцүүлгийн агуулга	Зохион байгуулсан огноо
1	Хууль тогтоох ажиллагаанд иргэдийн оролцоог хангах нь;	2021.05.04
2	Парламентын хянан шалгах үйл ажиллагаа;	2021.05.10
3	Хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянах шалгуур;	2021.05.04
4	Хууль зүйн дүн шинжилгээ: Албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоох нь;	2021.06.11
5	Төсвийн хяналт;	2021.10.12
6	Төсвийн дунд хугацааны төлөвлөлтөд анхаарах зүйлс;	2022.05.20
7	Хууль тогтоомжийн ил тод байдал ба шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоо;	2022.05.03
8	Зөвлөлдөх санал асуулга;	2022.05.09
9	Олон нийтийн санал бодлын судалгааны танилцуулга, дүн шинжилгээ.	2022.11.02

Судалгаа, ном, хэвлэл бэлтгэн түгээх хүрээнд: Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой нийт 39 судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнээс “Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангах” агуулгын хүрээнд 34 судалгааны ажлыг гүйцэтгэсэн бөгөөд нийт судалгааны ажлын 87.2 хувийг эзэлжээ. Нийт гүйцэтгэсэн судалгааны ажлыг тогтоолд заасан агуулгын хүрээнд ангилан үзвэл:

- Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангах хүрээнд 34 судалгаа;
 - Гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2 судалгаа;
 - Шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2 судалгаа;
- Нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 1 судалгаа тус тус гүйцэтгэсэн байна. /Хавсралт 2-оос Судалгааны ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу!/

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүрэн эхээр нь өдөр тутмын 5 сонин, орон нутгийн 21 сонинд нийтэлж, 72.000 ширхэг хэвлүүлж, орон даяар түгээжээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаарх хялбаршуулсан зурагт тайлбартай ном 20,000 ширхгийг хэвлүүлэн бүх шатны иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, их, дээд сургуулийн болон бусад томоохон номын сангуудад хүргүүлсэн байна.

Телевизийн мэдээ, нэвтрүүлэг бэлтгэн түгээх хүрээнд: МҮОНТ-тэй хамтран “Алганд багтсан эх орон”, “Хуулийн засаглал” зэрэг шинэ нэвтрүүлгүүдийг бий болгож, 12 цуврал нэвтрүүлэг бэлтгэн, нэвтрүүлгийн сүлжээнд албан ёсоор багтаасан байна.

МҮОНР-ийн 8:11 хөтөлбөрт Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээ, мэдээллийн агуулгыг багтааж, шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Их Хурлын гишүүдийн ярилцлагыг хөтөлбөрт тусган нэвтрүүлжээ.

Мөн Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн ач холбогдлыг олон нийтэд таниулж сурталчлах зорилгоор сэтгүүлч, судлаач, иргэдийн дунд шилдэг нэвтрүүлэг, нийтлэлийн уралдаан зарлаж, дүгнэсэн бөгөөд энэ хүрээнд нийт 12 нэвтрүүлэг, 36 нийтлэлийг уралдаанд ирүүлжээ.

Түүнчлэн хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл санаанд нийцүүлэх талаарх мэдээ, мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Хэвлэл, мэдээллийн студид бэлтгэн Парламент суваг, MNB, Eagle news, MN25, TV8, UBS, C1, TM, TB2, liveTV, Малчин, Өлзий зэрэг сувгуудаар түгээсэн байна.

Мобайл аппликейшн, олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан мэдээ, мэдээлэл түгээх хүрээнд: Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Монгол Улсын Үндсэн хууль: Нэмэлт, өөрчлөлт-2019” мобайл аппликэйшн бүтээж, App Store (iOS), Play Store (Android)-т байршуулсан нь иргэд, олон нийт, залуу үеийнхний сонирхол, хэрэглээнд нийцсэн шинэлэг ажил болжээ.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаарх тайлбар, мэдээлэл бүхий постерыг 3 хувилбараар бэлтгэж, давхардсан тоогоор 480 гаруй удаа цахим сайт болон олон нийтийн сүлжээгээр түгээн сурталчилсан байна.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт тусгагдсан хуулиудыг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн батлах цаг үеийн мэдээ, мэдээллийг бэлтгэн parliament.mn сайтад нийтэлж, хэвлэл мэдээллийн байгууллагуудад тухай бүр түгээн ажиллажээ.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу хяналт шинжилгээ хийхэд:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т тусгасан нийт 32 хуулиас 19 хууль буюу 59.4 хувийг тогтоолд нийцүүлэн баталж, 13 хууль буюу 40.6 хувийг батлаагүй байна;
2. Нийт батлагдсан 19 хуульд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т тусгасан хууль тогтоомжийн агуулга, үзэл баримтлалыг бүрэн тусгажээ;

3. Тогтоолын хавсралтад заасан хуваарьт багтаагүй ч Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг баталсан нь Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ;
4. Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас олон нийтийн мэдээ, мэдээллийн хэрэгслийг ашиглан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг улс орон даяар сурталчлах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажилласан байна.

Цаашид “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т тусгасан дараах 13 хууль тогтоомжийг тогтоолд нийцүүлэх. Үүнд:

1. Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангах агуулгын хүрээнд дараах 10 хуулийг нийцүүлэх.
 - Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль /нэмэлт, өөрчлөлт/;
 - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль /нэмэлт, өөрчлөлт/;
 - Байгаль орчныг хамгаалах тухай хууль /нэмэлт, өөрчлөлт/;
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон холбогдох бусад хууль /нэмэлт, өөрчлөлт/;
 - Цөмийн энергийн тухай хууль болон холбогдох бусад хууль /нэмэлт, өөрчлөлт/;
 - Үндэсний баялгийн сангийн тухай хууль /анхдагч хууль/;
 - Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль /нэмэлт, өөрчлөлт/;
 - Улс төрийн намын тухай хууль болон холбогдох бусад хууль /шинэчилсэн найруулга/;
 - Ард нийтийн санал асуулгын тухай хууль /нэмэлт, өөрчлөлт/;
 - Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль /анхдагч хууль/.
2. Гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд дараах 1 хуулийг нийцүүлэх.
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/.
3. Шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд дараах 1 хуулийг нийцүүлэх.
 - Шүүх байгуулах тухай хууль /нэмэлт, өөрчлөлт/.
4. Нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд дараах 1 хуулийг нийцүүлэх.
 - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/.

---000---